



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 1/04

Амардалай

Хорио цээрийн дэглэмийн сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйл 17.2.1 дэх заалт, Улсын мал мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн 2023 оны 01 дүгээр сарын 14 -ний өдрийн 23-1308, 23-1314 бүртгэлийн дугааруудтай шинжилгээний дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тус сумын Баянбулаг багийн нутаг " Модот ", Адаг ам"-т өвөлжиж буй малчны суурьт малын гоц халдварт " Бог малын мялзан" өвчин нэмэгдсэнтэй холбогдуулан 2023 оны 01 сарын 14-ний өдрөөс эхлэн 21 хоногийн хугацаатай хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2. Хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбогдуулан малын гоц халдварт богийн мялзан өвчинтэй тэмцэх, урьдчилсан сэргийлэх ажилд Гамшгаас хамгаалах бие бүрэлдэхүүнийг үүрэгжүүлж ажиллахыг сумын Шуурхай штабын дарга (С.Нарантунгалаг) -д даалгасугай.

3. Хорио цээрийн бус нутгийн малд шинжилгээ, үзлэг тандалт, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулж ажиллахыг Мал эмнэлгийн нэгжийн эмч М.Даваацэрэнд үүрэг болгосугай.

4. Гоц халдварт өвчнөөр хорогдсон болон өвчний явц, хэлбэр улирлын байдал зэргийг харгалзан тавилан муутай малыг устгах ажлыг зохион байгуулж ажиллахыг сумын Шуурхай штабын дарга (С.Нарантунгалаг) Мал эмнэлгийн тасгийн дарга (Д.Наранцэцэг) нарт даалгасугай.

5. Малчид иргэд олон нийтэд малын гоц халдварт бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх, гарын авлага, мэдээ мэдээллийг цахимаар олон нийтэд хүргэх, голомт сэжигтэй бүс малчдад малын хариуллага маллагаа, хорио цээрийн дэглэмийн журмыг мөрдөж ажиллах талаар хариуцлагын гэрээ байгуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Д.Наранцэцэг), Хөдөө аж ахуйн мэргэжилтэн (Б.Баттогтох) Багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

6. Дээрх үйл ажиллагаанд шаардлагатай санхүүгийн зардлын тооцоог гаргаж Гамшгаас урьдчилсан сэргийлэх зардлаас гаргаж шийдвэрлэхийг Засаг даргын Тамгын газрын Санхүү албаны дарга (Б.Уугантуяа), нягтлан бодогч (Г.Дэжидсүрэн)-д даалгасугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ

488001797